



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Аудитын тайлан

YAG-ын САГ-ын дарга,
тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Ч.Болд
Утас: 261885
Цахим хаяг:
boldch@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Сэрчхорол
Утас: 261628
Цахим хаяг:
serchhorols@audit.gov.mn

Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

~~2016 оны 01 дугаар сар~~
Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд (САГ-2016/18/САГ-ТТЗ) аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус газрын удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 02 дугаар сарын 24-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 02 дугаар сарын 29-нээс 2016 оны 03 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын орон нутгийн аудитын албаны ахлах аудитор С.Сэрчхорол хэрэгжүүлэв.

Үндэсний аудитын газар аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын тайланг 2016 оны 03 дугаар сарын 25-нд Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль болон бусад хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Иргэний нисэхийн ерөнхий газрын эрхэм зорилго нь Иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалт хийх, нислэгийн хөдөлгөөний удирдлага, холбоо, навигацийн техник тоног төхөөрөмж, мэдээлэл хангалт, нисэх буудал, газрын тусгай үйлчилгээ үзүүлж, үндэсний эдийн засагт хувь нэмэр оруулахад оршино.

Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх дараах чиг үүрэг, үйлчилгээг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

- ✚ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;
- ✚ Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- ✚ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэг, техникийн хэрэг тохиолдсон нөхцөлд шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах;
- ✚ Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;
- ✚ Агаарын хөлгүүдэд аюулгүй байдлын шалгалт хийх;
- ✚ Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх;
- ✚ Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх;
- ✚ Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх;
- ✚ Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх;
- ✚ Өмчийн бүх хэлбэрийн агаарын тээврийн байгууллагын бүтцэд мэргэжлийн хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл бүтцийг өөрчлөх;
- ✚ Нисэх буудлын болон агаарын навигацийн үйлчилгээний үнэлгээг олон улсад дагаж мөрдөж байгаа жишигт нийцүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээний үнэлгээг тогтоох, батлах;
- ✚ Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах;
- ✚ Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх;
- ✚ Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох
- ✚ Агаарын тээврийн байгууллагууд, нисэх буудлууд, нисэхийн аюулгүй байдлыг хангах байгууллага, агаарын навигацид холбогдолтой үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- ✚ Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах зэрэг үндсэн үүргүүдийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно, 15.3-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүнд харьяалагдах төсвийн шууд захирагчийг Засгийн газар тогтооно”, 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан

бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 15.4.2-т “энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газар нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлагийн 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгосон байна. Мөн тус газар нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаасаа санхүүждэг болно. Тус газрын үйл ажиллагааны талаар (ТАБ-СТА-А-1) маягтад тодорхой тусгасан.

Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт зардлын 1 хувиар 448.7 сая төгрөгөөр тооцсон бөгөөд жилийн эцсийн байдлаар шинэчилж, материаллаг байдлын түвшинг нийт зардал (122,329.6 сая төгрөгөөс)-аас 2.0 хувиар тооцож 2,446.6 сая төгрөгөөр тогтоов.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төслийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. (ТАБ-СТА-А-5)

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байгаа ба энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-ын стандарт, нягтлан бодох бүртгэлийн програмтай нийцсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргаж иржээ.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус газрын дотоод аудит нь 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, дотоод аудит хийх хуваарийг ИНЕГ-ын даргаар батлуулан, батлагдсан хуваарийн дагуу тус газрын дотоод зохион байгуулалтын нэгж болон түүний харьяа үйлдвэрлэл үйлчилгээний 17 байгууллагад төлөвлөгөөт, 8 газарт төлөвлөгөөт бус, Зам, тээврийн сайдын тушаалаар “МИАТ” ТӨХК-д хийсэн аудитын багт орж ажилласан байна.

2015 онд хийсэн аудитаар нийт 106 зөвлөмж өгсөн бөгөөд 1,616.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Дээрх зөвлөмжийн хэрэгжилт 2015 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар 86.0 хувьтай байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 онд агентлагийн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар хянуулж, батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангаас харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Мөн тус газрын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлын хувьд Сангийн сайд, Зам, тээврийн сайдын хамтарсан тушаалаар баталдаг байна.

Төрийн сангаас агентлагийн урсгал зардалд 3,500.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 3,439.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, батлагдсан төсвийг 61.2 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар хэмнэсэн байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээний албадын үйл ажиллагааны зардлыг 75,826.4 сая төгрөгөөр баталж, 75,699.8 сая төгрөгийн гүйцэтгэл гарч, батлагдсан төсвийг 126.6 сая төгрөгөөр буюу 0.2 хувиар хэмнэсэн байна.

Зам, тээврийн сайдын тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013-2014 оны цэвэр ашгаас 23,717.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийхээр баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 243 дугаар тогтоолоор “Чингис хаан” олон улсын нисэх буудлын талаар авах зарим арга хэмжээний тухай “Чингис хаан” олон улсын нисэх буудалд транзит заал барих, зорчигчдын танхимыг өргөтгөх, нисэх буудлын хөөрөх, буух зурвасыг засварлах,

шинээр агаарын хөлгийн зогсоол байгуулах ажлыг 20.4 (хорин тэрбум дөрвөн зуун сая) тэрбум төгрөгийн төсөвт өртөгт багтаан гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлэхийг Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүд зөвшөөрсөн байна.

Дээрх тогтоолын дагуу Зам, тээврийн сайд Н.Төмөрхүүгийн 2015 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Жагсаалт батлах тухай” 202 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014 оны ногдол ашиг 10,335.1 сая төгрөгөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг баталжээ.

Зам, тээврийн сайд М.Зоригт 2015 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 263 дугаар тушаал гарган өмнөх 202 дугаар тушаалыг хүчингүй болгож, Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014 оны ногдол ашиг 19.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн баталсан байна.

2015 онд 22,334.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна.Үүнээс АСЕМ-ийн бэлтгэл ажлын зардалд 15,445.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн шууд захирагчийн шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хангах зорилтын хүрээнд (shilendans.gov.mn) вэб хуудсанд төслийн шилэн дансыг байршуулсан байна.

2015 онд Иргэний нисэхийн ерөнхий газраас шилэн дансны системд оруулсан цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий судалгааг гаргуулж авлаа. Үүнд: Нийт 1102 гүйлгээгээр 477,533.7 сая төгрөгийн зардал гарсан байна.

Тус газрын шилэн дансны гүйлгээг зардлаар нь ангилж үзвэл орон нутаг, харьяа байгууллагын санхүүжилт 19,373.6 сая, улсын төсвийн орлогод 98,500.0 сая, сургалт, томилолтод 5,274.2 сая, тэтгэмж, орон сууцны дэмжлэгт 2,559.3 сая, тоног төхөөрөмж, гэрээт ажлын хөлсөнд 19,982.7 сая, харин арилжаагаар 304,199.4 сая төгрөгийн гүйлгээ гарсан байна.

Эндээс харахад тус газрын хувьд нэг гүйлгээ 2, банк хооронд шилжвэл 3, орон нутагт санхүүжилт гэж шивэгдээд, тухайн газартаа орлого, эргээд зарлага болж, хэд дахин шивэгдэж байна. Үүнээс үзэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хувьд шилэн дансны бүртгэлийг эргэж харах шаардлага тавигдаж байна.

Олж тогтоосон эрсдэл, түүний үр дагавар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд аудит хийх төлөвлөгөөгөөр төлөвлөлтийн шатанд 4 дансанд 4 эрсдэл байж болзошгүй гэж тогтоосны дагуу нарийвчилсан сорилын аргаар тулган баталгаажуулах, ажиглах,

харьцуулах зэрэг сорилыг гүйцэтгэлээ. Мөн мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийг нэмж тулган баталгаажууллаа.

Санхүүгийн аудитын төлөвлөлтийн үе шатыг 11, гүйцэтгэлийн үе шатыг 9, тайлагналын үе шатыг 7 ажилбараар тус тус СТАУС програмд оруулж, аудитын менежер, газрын дарга, тэргүүлэх аудитораар хянууллаа.

Мөн үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, нотлох баримтуудыг тусгайлан ажлын баримтаар програмд орууллаа.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, орлого, авлага, өглөгийн дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн шалгалаа.(ТАБ-СТА-В-3)

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Үүнд:

1. Батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч гадаад томилолт, өндөр насны тэтгэмж, шагнал урамшуулал, сэлбэг хэрэгсэл, гадаад сургалт, семинар, нормын болон дүрэмт хувцасны зардал 812.3 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Мөн шүүхийн шийдвэр болон төлбөрийн акт, банкны хураамж зэрэг төсөвт суугдаагүй зардалд ч хөрөнгө мөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө мөнгийг хэмнэлттэй зарцуулах, төлөвлөлтийн үндэслэлийг боловсронгуй болгох талаар аудитын зөвлөмж өгөх.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагуудын шийдвэрээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн ажилтнуудад шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг буцаан олгох, ажилд эргүүлэн авах асуудал цөөнгүй гарч байгаагаас үргүй зардал гарч байна. Тухайлбал, 2015 онд шүүхийн шийдвэрээр 11 ажилтанд 155.2 сая төгрөгийн цалин, НДШ-д 7.2 сая төгрөг нөхөн төлжээ.

Шийдвэрлэсэн: Ажилтныг ажлаас чөлөөлөх, халах шийдвэр гаргахдаа хууль эрх зүйн үндэслэлийг үнэн зөв тодорхойлох асуудлыг анхаарч ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх.

3. Зам тээврийн яамны ажилтнуудын гадаад томилолтын зардалд 66.6 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан “тухайн

шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчжээ.

Шийдвэрлэсэн: Зам, тээврийн яамны ажилтнуудын гадаад томилолт болон бусад зардалд хөрөнгө зарцуулах асуудлыг хууль эрх зүйн хүрээнд мөрдөж ажиллах, төлбөрийн акт тогтоох.

4. Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүд ашиглагдаж байгаа програм нь гүйлгээ баланс, мөнгөн гүйлгээг нэгтгэж гаргахгүйгээс өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн програмыг шинэчлэх талаар зөвлөмж өгөх.

5. Тус газрын харьяа салбар болон орон нутгийн нисэх буудлын эзэмшилд байгаа үндсэн хөрөнгө, зардлыг үйлдвэрлэлийн албанд нэгдсэн журмаар бүртгэж байгаа нь УСНББОУС 1-санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС 17, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: УСНББОУС-ын 1, 17, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, оршин байх батламж, мэдэгдлийг мөрдөж ажиллах.

ИНЕГ-ын харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн тайланд:Иргэний нисэхийн ерөнхий газрын агентлаг, үйлдвэрлэлийн алба, Чингис хаан олон улсын нисэх буудал, сэргээн засал, сувиллын цогцолбор, газрын үйлчилгээний алба болон 14 аймгийн нисэх буудал, нийт 21 байгууллагын тайлан нэгтгэгддэг байна.

Дээрх байгууллагуудаас Хөвсгөл аймгийн нисэх буудлаас бусад байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлттэй авчээ. Дорнод аймгийн нисэх буудал “Итгэл” үзүүлсэн байгууллагад багтсан байна. Өнөөдрийн байдлаар Говь-Алтай, Баянхонгор, Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нисэх буудалд хийсэн аудитын тайлан ирээгүй байна.

Аудит хийсэн байгууллагуудын тайлангаас үзэхэд зөрчил, дутагдал багагүй илэрсэн байна. Тухайлбал,

- ✚ **Газрын тусгай үйлчилгээний алба:** 112.9 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй;
- ✚ **Чингис хаан олон улсын нисэх буудал:** цалингийн зардлыг 162.4 сая, засварын зардлыг 61.6 сая, буцалтгүй тусламжийн зардлыг 27.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн;

- ✚ **Сэргээн засах, үйлчилгээний цогцолбор:** Санхүүгийн тайланг өмнөх онтой зэрэгцүүлэх ба тодруулгыг бэлтгэн гаргаагүй, бэлэн мөнгөний тооцоонд цахим буюу кассын машин ашигладаггүй, ажилтнуудын үр дүнгийн урамшууллын үзүүлэлт чанаргүй, хавтгайруулан олгосон дутагдал өмнө нь гарсан ч засагдаагүй, зардлын ангиллыг зөв ангилж бүртгээгүй г.м;
- ✚ **Өвөрхангай аймгийн нисэх буудал:** ИНЕГ-т өгөх сувгийн төлбөрт улирал бүр төлөх 9.7 сая, жилдээ 38.9 сая төгрөгийн өглөг анхан шатны баримтаар нотлогдоогүй;
- ✚ **Хөвсгөл аймгийн нисэх буудал:** Бараа материалын эхний үлдэгдэл эд хариуцагчийн тайлангаар 198.8 сая, журналаар 187.9 сая, зөрүү 10.9 сая төгрөгөөр тайлагнагдсан, сансрын холбооны түрээсийн зардалд 38.9 сая төгрөгийг бүртгэсэн нь анхан шатны баримтгүй, санхүүжилтээс буцаасан 25.0 сая төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн, ИНЕГ-аас Хэнгэрэгтэй уулан дахь харуулын үйл ажиллагаанд зарцуулсан 10.4 сая төгрөгийн шатахууныг өөрийн зардалд тооцож бүртгэсэн, ажил олгогчоос төлөх ХЧТАТ-д олгосон 1.1 сая төгрөгийг цалингийн зардалтай давхардуулан зардалд тооцсон, баримтын бүрдэлгүй 47.7 сая төгрөг зарцуулсан;
- ✚ **Увс аймгийн нисэх буудал:** Шийдвэргүйгээр 63.0 мянган төгрөгийн цалин олгосонд төлбөрийн акт тогтоосон;
- ✚ **Ховд аймгийн нисэх буудал:** Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг цаг тухайд нь оруулж байх;
- ✚ **Хэнтий аймгийн нисэх буудал:** Нисэх буудлын эзэмшилд байгаа хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Иргэний нисэхийн ерөнхий газар нь 21 салбар байгууллага, нийт 2100 гаруй ажилтантай “Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” гэж Улсын бүртгэлд бүртгэгджээ. Мөн Засгийн газрын тогтоолоор 2012 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэж тодорхойлогджээ.

Ийнхүү тус газар нь хоёрдмол статустай байгааг холбогдох байгууллагууд цаашид анхаарах нь зүйтэй байна.

Мөн 2015 онд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын **үүргийг түр орон гүйцэтгэгчээр** 3 хүн томилогдон ажилласан бөгөөд бүтэц, зохион байгуулалтын талаар Т.Лхагвасүрэн 5, Ц.Эрдэнэбилэг 32, Г.Нямдаваа 11 удаа тушаал шийдвэр гаргасан байна.

Тайлант онд орон нутгийн нисэх буудлуудын галчийн нэг орон тоонд 2 ажилтан (улирлын чанартай), 2016 онд АСЕМ-ийн уулзалт зохион байгуулах, 2017 онд шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орохтой холбогдуулан Чингис хаан олон улсын нисэх буудалд гэрээгээр ажилтнууд авч ажиллуулжээ.

Зам, тээврийн сайдын тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын тухайн оны цэвэр ашгаас тооцож хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталдаг бөгөөд энэ нь хэд хэдэн он дамжин санхүүжигддэгээс тайлант онд батлагдсан төсвийн гүйцэтгэл, авлага, өглөгт зохих ёсоор нөлөөлдөг байна. Тухайлбал, 2015 онд тус

газрын авлага өмнөх оноос 8,633.3 сая төгрөг буюу 19.9 хувиар өссөн бөгөөд энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 2,891.1 сая, цэвэр ашгаас санхүүжигдсэн 9,078.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний дуусаагүй ажлын үлдэгдэлтэй холбоотой байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй боловч цэвэр ашгаас хийгдэж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд анхаарал тавих хэрэгтэй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 1041.3 сая төгрөгийн алдаа дутагдалд 5 зөвлөмж өгч, 66.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.Дээрх алдаа зөрчил нь материаллаг түвшингээс хэтрээгүй болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг гаргаж ирүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан, хавсралтуудыг тус тус хавсаргав.



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

YAG-ын САГ-ын дарга,
тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер Ч.Болд
Утас: 261885
Цахим хаяг:
boldch@audit.gov.mn

Ахлах аудитор:
С.Сэрчхорол
Утас: 261628
Цахим хаяг:
serchhorols@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар
Засгийн газрын IY байр

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Зардал.....	3
Асуудал 2	
Зардал.....	3
Асуудал 3	
Зардал.....	4
Асуудал 4	
Програм хангамжийг сайжруулах.....	4
Асуудал 5	
Үндсэн хөрөнгө.....	5

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал: 1 Зардал**Тэргүүлэх ач холбогдол № 1****ҮАГ-ын ажиглалт**

Батлагдсан төсөвт зардлыг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч гадаад томилолт, өндөр насны тэтгэмж, шагнал урамшуулал, сэлбэг хэрэгсэл, гадаад сургалт, семинар, нормын болон дүрэмт хувцасны зардлууд 812.3 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Мөн шүүхийн шийдвэр болон төлбөрийн акт, банкны хураамж зэрэг төсөвт суугдаагүй зардалд хөрөнгө мөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

ҮАГ-ын зөвлөмж

Батлагдсан төсвийн хүрээнд хөрөнгө мөнгийг хэмнэлттэй зарцуулах, төсвийн төлөвлөлтийг үндэслэлтэй боловсруулах

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Асуудал: 2 Зардал**Тэргүүлэх ач холбогдол № 2****ҮАГ-ын ажиглалт**

Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлагуудын шийдвэрээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн ажилтнуудад шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны цалинг буцаан олгох, ажилд эргүүлэн авах асуудал цөөнгүй гарч байгаагаас үргүй зардал гарч байна. Тухайлбал, 2015 онд шүүхийн шийдвэрээр 11 ажилтанд 155.2 сая төгрөгийн цалин, НДШ-д 7.2 сая төгрөг нөхөн төлжээ.

Эрсдэл

Үр ашиггүй зардал өсөх;

ҮАГ-ын зөвлөмж

Удирдлагын тушаал шийдвэр гаргахдаа хууль эрх зүйн үндэслэлийг баримталж, эрсдэл үүсэх нөхцөл боломж гаргахгүй ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Асуудал: 3 Зардал**Тэргүүлэх ач холбогдол № 3****ҮАГ-ын ажиглалт****ҮАГ-ын зөвлөмж**

Зам тээврийн яамны ажилтнуудын гадаад томилолтын зардалд 66.6 сая төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасан “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчжээ.

Зам, тээврийн яамны ажилтнуудын гадаад томилолт болон бусад зардалд хөрөнгө зарцуулах асуудлыг хууль эрх зүйн хүрээнд мөрдөж ажиллах, төлбөрийн акт тогтоох.

Эрсдэл**Үйлчлүүлэгчийн хариу**

Төсвийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зориулалтаар нь үр ашигтай зарцуулах зарчим алдагдах, үргүй зардал гаргах;

Зөвшөөрч байна.Цаашид анхаарч ажиллана.

Асуудал:4 Програм хангамжийг сайжруулах**Тэргүүлэх ач холбогдол № 4**

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүд ашиглагдаж байгаа програм нь гүйлгээ баланс, мөнгөн гүйлгээг нэгтгэж гаргахгүйгээс өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжид зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг баталж, биелэлтэд нь хяналт тавих” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүгийн програмыг шинэчлэх талаар зөвлөмж өгөх.

Эрсдэл**Үйлчлүүлэгчийн хариу**

Санхүүгийн програмаас шаардлагатай мэдээлэл, тайланг нэгтгэн гаргаж чадахгүйгээс тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх;

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Асуудал:5 Үндсэн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол № 5**

Тус газрын харьяа салбар болон орон нутгийн нисэх буудлын эзэмшилд байгаа үндсэн хөрөнгө, зардлыг үйлдвэрлэлийн албанд нэгдсэн журмаар бүртгэж байгаа нь УСНББОУС 1-санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС 17, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Эрсдэл

Үндсэн хөрөнгө эзэнгүйдэх, элэгдэл хорогдлын зардал болон бусад тухайн салбар, орон нутгийн зардалд тооцогдохгүй байх, орхигдох;

УСНББОУС-ын 1, 17 болон санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, оршин байх батламж, мэдэгдлийг мөрдөж ажиллах.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.НЯМДАВАА ТАНАА

2016.03.25 № 3/545
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА



\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0325SAG15.Docx

УХА0122

070512

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,145,943,782.86	82,688,733,268.09
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,716,311,587.69	23,642,589,949.35
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	27,773,154.29	70,225,324.40
31110	Төгрөг	27,773,154.29	70,225,324.40
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,688,538,433.40	23,572,364,624.95
31210	Төгрөг	28,688,538,433.40	23,572,364,624.95
31211	Төрийн сангийн харилцах		1,560,601,690.20
31213	Арилжааны банк дахь харилцах	28,688,538,433.40	22,011,762,934.75
33	АВЛАГА	43,247,311,070.47	51,880,539,371.90
33401	Дансны авлага /ТӨҮГ/	5,911,898,346.64	15,935,163,834.27
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	393,210,031.60	
33500	Бусад авлага	36,942,202,692.23	35,945,375,537.63
33510	Байгууллагаас авах авлага	36,942,202,692.23	35,945,375,537.63
34	УРЬДЧИЛГАА	182,137,575.54	1,277,057,260.37
34600	Урьдчилж гарсан зардал	182,137,575.54	1,277,057,260.37
35	БАРАА МАТЕРИАЛ	6,000,183,549.16	5,888,546,686.47
35400	Хангамжийн материал	5,991,221,610.50	5,879,584,747.81
35470	Бусад хангамжийн материал	5,991,221,610.50	5,879,584,747.81
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад	8,961,938.66	8,961,938.66
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	190,473,172,832.24	185,037,417,352.72
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	190,473,172,832.24	185,037,417,352.72
39200	Биет хөрөнгө	187,481,534,919.48	181,961,502,846.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,874,837,968.46	158,493,129,396.53
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,118,094,592.20)	(59,810,461,584.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	18,751,174,787.54	19,567,077,536.54
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,201,626,431.14)	(15,620,426,243.68)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	105,189,133,837.53	105,243,888,675.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,620,102,984.43)	(59,000,244,942.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,241,744,754.04	5,408,635,371.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,507,237,829.47)	(3,788,519,291.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,660,577,639.71	7,817,836,027.27
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,891,446,238.66)	(4,642,520,216.58)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	28,102,574,008.10	28,293,108,117.42
39300	Биет бүс хөрөнгө	2,991,637,912.76	3,075,914,505.97
39301	Програм хангамж	8,112,967,354.94	8,197,243,948.15
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,121,329,442.18)	(5,121,329,442.18)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	268,619,116,615.10	267,726,150,620.81
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,171,564,131.77	6,497,109,667.18
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,171,564,131.77	6,497,109,667.18
41200	Богино хугацаат зээлийн өглөг	5,160,719,238.37	2,431,252,008.43
41210	Төгрөг	2,729,467,229.94	-

41216	Арилжааны банк	2,729,467,229.94	
41220	Гадаад валют	2,431,252,008.43	2,431,252,008.43
41226	Бусад гадаад эх үүсвэр	2,431,252,008.43	2,431,252,008.43
41300	Өглөг	3,990,364,653.05	4,009,920,583.97
41360	Бусад өглөг	3,990,364,653.05	4,009,920,583.97
41361	Байгууллагад төлөх өглөг	556,685,962.32	753,071,345.36
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.02	8,947,933.00
41363	Татварын өр	-	-
41364	НДШ - ийн өглөг	10,810,231.19	341,005,160.91
41365	Ноогдол ашгийн өглөг		
41366	Дансны өглөг	3,422,868,459.52	2,906,896,144.70
41400	Урьдчилж орсон орлого	20,480,240.35	55,937,074.78
41440	Бусад урьдчилж орсон орлого	20,480,240.35	55,937,074.78
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	261,009,180,163.11	261,352,988,952.45
51	Засгийн газрын хувь оролцоо	261,009,180,163.11	261,352,988,952.45
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	228,011,429,556.38	225,569,216,113.02
51101	Өмч: төрийн	228,011,429,556.38	225,569,216,113.02
51200	Хуримтлагдсан үр дүн	32,997,750,606.73	35,783,772,839.43
51210	Өмнөх үеийн үр дүн		30,908,423,275.39
51220	Тайлант үеийн үр дүн	32,997,750,606.73	4,875,349,564.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	270,180,744,294.88	267,850,098,619.63

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	111,672,797,614.92	125,152,470,757.04
11	ТАТВАРЫН ОРЛОГО	107,297,527,268.94	121,298,221,109.48
110	Орлогын албан татвар	107,297,527,268.94	121,298,221,109.48
1100	Хувь хүний орлогын албан татвар	107,297,527,268.94	121,298,221,109.48
110002	Үйл ажиллагааны орлого	107,297,527,268.94	121,298,221,109.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,375,270,345.98	3,854,249,647.56
120	Нийтлэг татварын бус орлого	4,375,270,345.98	3,854,249,647.56
120002	Хүүгийн орлого	617,171,541.68	807,285,630.89
120009	Бусад орлого	3,758,098,804.30	3,046,964,016.67
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	96,490,873,486.68	122,329,658,729.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	96,490,873,486.68	122,329,658,729.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	96,490,873,486.68	122,329,658,729.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,490,873,486.68	122,329,658,729.86
210811	Ерөнхий ба удирдлагын зардал		

		76,127,969,521.56	104,741,102,726.83
210813	Бусад зардал	11,652,769,285.19	13,365,055,483.28
210814	Орлогын татварын зардал	8,710,134,679.93	4,223,500,519.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	<u>15,181,924,128.24</u>	<u>2,822,812,027.18</u>
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	5,488,168,751.57	2,052,537,536.86
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	5,488,168,751.57	2,052,528,214.64
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		9,322.22
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	<u>20,670,092,879.81</u>	<u>4,875,349,564.04</u>

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	<u>175,348,626,288.34</u>	<u>467,135,488,069.97</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>171,704,781,388.34</u>	<u>449,639,749,128.32</u>
120	Нийтлэг татварын бус орлого	171,704,781,388.34	449,639,749,128.32
120007	Навигацийн орлого	168,765,959,536.90	184,080,895,714.92
120009	Бусад орлого	2,938,821,851.44	265,558,853,413.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>3,643,844,900.00</u>	<u>17,495,738,941.65</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,643,844,900.00	17,495,738,941.65
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,643,844,900.00	17,495,738,941.65
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>159,442,949,635.54</u>	<u>460,894,187,533.28</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>159,442,949,635.54</u>	<u>460,894,187,533.28</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>159,442,949,635.54</u>	<u>460,894,187,533.28</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,767,532,645.83	34,335,020,342.19
210106	Ажиллагчдад төлсөн	31,767,532,645.83	34,335,020,342.19
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,408,643,148.01	8,028,608,345.33
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,408,643,148.01	8,028,608,345.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,461,532,093.47	3,901,780,025.16
210305	Ашиглалтын зардалд төлсөн	4,461,532,093.47	3,901,780,025.16
2104	Хангамж, бараа материалын зардал	6,301,115,437.16	7,390,159,937.47
210407	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг		

	хэрэгсэлд төлсөн	2,923,659,546.57	4,536,068,712.54
210408	Бараа материал худалдан авахад төлсөн	3,377,455,890.59	2,854,091,224.93
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,504,126,311.07	407,238,618,883.13
210816	Татварын байгууллагад төлсөн	17,713,646,156.26	11,804,876,587.27
210817	Даатгалын төлбөрт төлсөн	123,861,277.75	1,288,042,034.23
210818	Бусад мөнгөн зарлага	91,666,618,877.06	394,145,700,261.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<u>15,905,676,652.80</u>	<u>6,241,300,536.69</u>
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	26,164,444,521.68	799,142,989.00
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	25,547,272,980.00	
140007	Хүлээн авсан хүүний орлого	617,171,541.68	799,142,989.00
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,010,460,527.59	12,114,165,164.03
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,010,460,527.59	12,114,165,164.03
2200	Дотоод эх үүсвэрээр	27,010,460,527.59	12,114,165,164.03
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,675,000.00	122,218,333.08
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	27,005,785,527.59	11,991,946,830.95
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<u>(846,016,005.91)</u>	<u>(11,315,022,175.03)</u>
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	15,059,660,646.89	(5,073,721,638.34)
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,656,650,940.80	28,716,311,587.69
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,716,311,587.69	23,642,589,949.35

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,234,399,927.13		16,674,668,880.03		217,909,068,807.16
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,234,399,927.13	-	16,674,668,880.03	-	217,909,068,807.16
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	26,777,029,629.25		(4,347,011,153.11)		22,430,018,476.14
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
7	Тайлант үеийн үр дүн	-		20,670,092,879.81		20,670,092,879.81
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	228,011,429,556.38	-	32,997,750,606.73	-	261,009,180,163.11
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-		-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	228,011,429,556.38	-	32,997,750,606.73	-	261,009,180,163.11
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	(2,442,213,443.36)		(2,089,327,331.34)		(4,531,540,774.70)
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
15	Тайлант үеийн үр дүн	-		4,875,349,564.04		4,875,349,564.04
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	225,569,216,113.02	-	35,783,772,839.43	-	261,352,988,952.45

